



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хөтөлбөрийг” гэснийг “журмыг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална” гэснийг “бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтын “баталж,” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР